

"Шинэ хөдөө-2" төслийн хүрээнд Ховд аймгийн Буянт суманд Ховд агро парк төслийн талбайд Ховд голоос ус татах ажил хийж гүйцэтгэх ажлын даалгавар

8/15/2024		Ховд хот
1	Төсөл боловсруулах үндэслэл	Монгол улсын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 сарын 11-ний өдрийн А/14 тушаалын хавсралтын XVI. 3.32 Шинэ хөдөө төсөл /Ховд/ орон нутагт эрх шилжүүлсэн
2	Байршил	Ховд аймгийн Буянт сумын Ховд агро парк төслийн талбайд
3	Зориулалт	Ховд аймгийн Буянт суман дахь Ховд агро парк төслийн талбайд Мянгад сумын баруун талын Ховд голоос насос, хоолой ашиглан ус татах ажлыг хийж гүйцэтгэх, /хөв цөөрөм байгуулах цэг хүртэл/
4	Бүтээн байгуулах хугацаа	2024.11.30-ны дотор
5	Захиалагч	Ховд аймгийн ЗДТГ, "Шинэ хөдөө" төсөл, Шинэ Ховд ББХК
6	Ерөнхий үзүүлэлт	Ховд агро парк төслийн хүрээнд Ховд голоос усалгааны шугам татан Ховд аймгийн иргэдийн газар тариалангын усалгаа хийх нийт 3500м урттай Ф450 мм-ийн диаметртэй шугам хоолой татах ажил байна. Ховд агро парк төслийн зүгээс 3500м хоолой, ус шахах насосыг бэлэн болгосон байна.
7	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, баримтлах үндсэн норм дүрэм, хууль, стандартууд	Усны тухай хууль болон холбогдох бусад хуулиуд Норм дүрэм: Усжуулалтын систем, түүний байгууламж /БНБД33-09-10/ Барилгын норм ба дүрэм 33-01-03 Усны барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үндсэн журам Барилгын норм ба дүрэм 33-02-07 Гидротехникийн туннель Барилгын норм ба дүрэм 33-03-05 Голын гидротехникийн барилга байгууламж Барилгын норм ба дүрэм 33-04-09 Усны барилга байгууламжийн суурь Барилгын норм ба дүрэм 33-04-09 Усны барилгын ачаалал ба үйлчлэл Барилгын норм ба дүрэм 40-02-16 Усны хангамж, гадна сүлжээ ба байгууламж Бусад холбогдох хууль, журам, стандарт, норм дүрэм
8	Толгойн барилга, байгууламж	Мянгад сумын баруун талд Ховд голын баруун эрэгийн тохойг ашиглан толгойн барилгыг барьж байгуулах. Үүнд: Усыг тодорхой хэмжээнд хашиж, насос чөлөөтэй сорох хэмжээнд усыг гүн болгох Усны доод хөрсийг чулуугаар дэвсгэр хийж, жижиг элс орохоос сэргийлэх Толгойн барилга нь тусдаа техникийн байртай байх бөгөөд тухайн хэсэгт мал, амьтан орохоос сэргийлсэн хашаа хамгаалалттай байна. Толгойн барилга нь ус шахах, шавхах тусдаа тохируулгатай байна. Хоолойн сорох хэсэгт шүүлтүүртэй байх Цахилгааны шийдийг бүрэн угсарч, холбосон байна

Хийгдэх ажлын
тодорхойлолт, тоо хэмжээ

9	Ус дамжуулах хар хоолой татах	Ховд голын баруун эрэгт байгуулагдсан толгойн барилгаас Ховд агро парк төслийн талбай хүртэл 3500 метр хоолойг татах ажлыг хийж гүйцэтгэх ф450мм хоолойг хооронд залгахдаа халааж наах технологи ашиглах Ус дамжуулах хоолойг газрын гүнд 1.5м-ээс дээш гүнд шороонд булах Ховд агро парк төслийн угсарсан 2 ширхэг усжуулалтын системийн төвийг дайруулан уг хоолойг татах бөгөөд 500метр дутамж 1 ширхэг усыг газрын гадрагаруу гаргах хоолой болон түүнд тохирсон усны хаалт хийж өгөх
10	Санхүүжилт	Тус ажлыг "Шинэ хөдөө" төслөөс 200 000 000 төгрөгөөр буюу 50 хувийг санхүүжүүлэх бөгөөд үлдэгдэл санхүүжилтийг ашиглагч талаас 2 жилийн хугацаанд шийдвэрлэнэ.
11	Нэмэлт нөхцөл	Хоолойн төгсгөлт ус хуримтлуулах усан сан байгуулах бөгөөд тус газар нь хаврын шар усны үер борооны усыг хуримтлуулах боломжтой байх. Гүйцэтгэгчийн зүгээс усан сан байгуулах хүртэлх ажлыг хийж гүйцэтгэх

Боловсруулсан:

ХАП төсөл Д. Нямдаваа



ОРЛОГЧ ДАРГА **БАТЛАВ** Х.БАТБОЛД

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ "ШИНЭ ХӨДӨӨ"
/ХОВД/ ТӨСЛИЙН 7-р БАГЦЫН АЖЛЫН ДААЛГАВАРЫН ТЕХНИКИЙН
ТОДОРХОЙЛОЛТ, ШААРДЛАГА

Хөдөөгийн багуудад олгох Мотоцикл

2024 Ховд аймаг

№	Төсөл боловсруулах үндэслэл	Монгол улсын Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 сарын 11-ний өдрийн А/14 тушаалын хавсралтын XVI. 3.32 Шинэ хөдөө төсөл /Ховд/ орон нутагт эрх шилжүүлсэн
1	Байршил	Ховд аймаг хөдөөгийн зарим сум, багуудад
2	Зориулалт	Хөдөөгийн зарим шаардлагатай багуудын эмч, багийн даргын ажил үүргээ гүйцэтгэх, иргэдийн төрийн үйлчилгээг хүргэхэд шаардлагатай мотоциклийг олгох
3	Захиалагч	Ховд аймгийн ЗДТГ, "Шинэ хөдөө" төсөл
4	Хийгдэх ажлын тодорхойлолт, тоо хэмжээ	Техникийн үзүүлэлт Загвар: Dayun150-3N, Dayun-26A, Dayun150-Super загварууд байх. Dayun150-3N загвараас хамгийн багадаа 20 ширхэг байна. Мотор: 150СС-20 ширхэг, 200СС-ээс 15 ширхэг, Нийт 35 ширхэг мотоцикл Гэрэл: Лед гэрэл Дугуй: 18" хэмжээтэй, 13 салаа обуд, Урд дугуй 3.00, Хойд дугуй 3.25 хэмжээтэй пакришкатай Суудал: Өргөн зөөлөн суудалтай, Хамгаалалт: Явах эд анги, өвдөгний хамгаалалт, бусад хамгаалах болон холбогч эд анги бүгд сайн чанарын төмрөөр хийгдсэн байх Хянах: Электрон хянахтай
5	Нэмэлт нөхцөл	Нийлүүлэгч нь Ховд аймагт авч ирж, 100 хувь угсраж, шатахуун хийж, явахад бэлэн болгосон байна.

122.5.

ХЯНАСАН:
ХБТХОХ-ИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ **Д.ЭРДЭНЭБАТ**

БОЛОВСРУУЛСАН:
ХБТХОХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН **Ц.ПҮРЭВСҮРЭН**